

Ремикон ХК

Компанийн засаглалын тухай мэдээлэл

Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй.

ТУЗ-н дарга: Х.Гантулга

ТУЗ-н хараат гишүүд: Б.Батсайхан, Х.Хашчимэг, Ч.Мөнгөнсүх, Ц.Эрдэнэбаяр, Э.Мөнхсайхан

ТУЗ-н хараат бус гишүүд: Б.Гүнболд, Д.Алтанхуяг, С.Баянмөнх

Гүйцэтгэх захирал: Э.Мөнхсайхан

Удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

ТУЗ-н дэргэдэх хороодын мэдээлэл

1. Аудитын хороо

Чиг үүрэг: Компанийн нягтлан бодох бүртгэл, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа зэрэг асуудалд хяналт тавих, тодорхой асуудлуудыг шийдэх, ТУЗ-д мэдээлэл өгөх үүрэг бүхий байгууллага юм.

Хариуцлага: Аудитын хорооны гишүүд хорооноос гаргасан шийдвэр дүгнэлтийн хүрээнд хариуцлага хүлээнэ. Аудитын хорооны журамд заагдсан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс компанид хохирол учирсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

Гишүүдийн нэр:

Хорооны дарга С.Баянмөнх

Боловсрол: АНУ-ын "TEXAS WESLEYAN UNIVERSITY" сургуулийг Бизнесийн Удирдлагын Магистр, МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ КТМС-ийг Бизнесийн Удирдлагын Магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Ажил эрхлэлт: АНУ-ын "RED HORSE REALTY" INC Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн шинжээч, "ORIENTAL GARDEN" INC Борлуулалтын туслах менежер, МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ, КТМС-д Багш, 2012 оноос одоог хүртэл "BP MONGOLIA GROUP" ХХК-д Гүйцэтгэх захирлын албан тушаал эрхэлж байна.

Хорооны гишүүн Б.Батсайхан

Боловсрол: 2000 онд Япон улс "Хитоцубаши" их сургуулийг маркетинг өрсөлдөөний стратеги, суралцаж төгссөн.

Ажил эрхлэлт: 2000-2002 онд Япон улсын "А. Т. Kearney" компанид Маркетингийн зөвлөх, 2002-2003 онд Япон улсын "UNIQLO" компанид маркетингийн менежер, 2004-2005 онд "Эм Си Эс Групп"-д дэд ерөнхийлөгч, 2005-2007 онд "Гоёо" ХХК-д Гүйцэтгэх захирал, 2009 оноос одоог хүртэл "Монголын хөрөнгө оруулалтын сан"-ийн захирлаар ажиллаж байна.

Хорооны гишүүн Б.Гүнболд

3. Нэр дэвшүүлэх хороо

Чиг үүрэг: Компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалд хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн иргэнийг шударгаар, хараат бусаар нэр дэвшүүлэх, шударгаар сонгогдох нөхцөлөөр хангах чиг үүрэгийг баримтална.

Хариуцлага: Нэр дэвшүүлэх хорооны гишүүд хорооноос гаргасан шийдвэр дүгнэлтийн хүрээнд хариуцлага хүлээнэ. Нэр дэвшүүлэх хорооны журамд заагдсан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс компанид хохирол учирсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

Гишүүдийн нэр:

Хорооны дарга Б.Гүнболд

Боловсрол: КТМС сургуулийг 1995 онд Автомат электроник мэргэжлээр, МУИС сургуулийг 1996 онд Хятал хэл мэргэжлээр, БНХАУ-д Зүүн өмнөдийн их сургуулийг 2000 онд Архитектурын инженер, Автралид Свинбүрн их сургуулийг 2013 онд Барилгын менежмент магистраар суралцаж төгссөн.

Ажил эрхлэлт: 2001 оноос “Ундрага” ХХК компанид Барилгын менежер, 2002 онд “Зоос банк” ХХК-д албадын даргаар, 2004-2015 онд Анагист ХХК-д Захиралаар тус тус ажиллаж байсан.

Хорооны гишүүн Д.Алтанхуяг

Боловсрол: МУИС сургуулийг 1993 онд Электроник инженер мэргэжлээр, Зах зээлийн судалгааны хүрээлэн 1995 онд Гадаад худалдааны менежер, Удирдлагын академийг 2005 онд Удирдахуйн ухааны магистраар суралцаж төгссөн.

Ажил эрхлэлт: 2005 оноос “Дорнод интернэшнл” компанид Гүйцэтгэх захирал, 2012 оны 01-р сараас өнөөг хүртэл “Аэр Зам” ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Хорооны гишүүн Х.Хашчимэг

Боловсрол: 1993 онд Анагаах ухааны дунд сургуульд Ерөнхий сувилагчаар, МУИС-ийг 1995 онд Хими Технологич мэргэжлээр, 2004 онд МУИС ХЗСургууийн эрх зүйч баклавр мэргэжлээр тус тус суралцан төгссөн.

Ажил эрхлэлт: 2003 оноос Хера инвестмент ХХК-д Эрх зүйч, 2013 оноос 2017 онд Ремикон ХК гүйцэтгэх захирал, 2018 оноос өнөөг хүртэл Вертекс майнинг ХХК-д гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.

ТУЗ хороод болон гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцэж дүгнэлт гаргаж байгаагүй. Жил бүр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Гүйцэтгэх удирдлага, ТУЗ болон Хороодын ажлын тайланг танилцуулдаг.

Боловсрол: КТМС сургуулийг 1995 онд Автомат электроник мэргэжлээр, МУИС сургуулийг 1996 онд Хятал хэл мэргэжлээр, БНХАУ-д Зүүн өмнөдийн их сургуулийг 2000 онд Архитектурын инженер, Автралид Свинбүрн их сургуулийг 2013 онд Барилгын менежмент магистраар суралцаж төгссөн.

Ажил эрхлэлт: 2001 оноос "Ундрага" ХХК компанид Барилгын менежер, 2002 онд "Зоос банк" ХХК-д албадын даргаар, 2004-2015 онд Анагист ХХК -д Захиралаар тус тус ажиллаж байсан.

2. Цалин урамшууллын хороо

Чиг үүрэг: Компанийн цалин урамшууллын системд хяналт тавих, компанийн удирдах албан тушаалтнуудын цалин урамшууллын системийг боловсруулах хяналт тавих үндсэн чиг үүрэг бүхий байгууллага байна.

Хариуцлага: Цалин урамшууллын хорооны гишүүд хорооноос гаргасан шийдвэр дүгнэлтийн хүрээнд хариуцлага хүлээнэ. Цалин урамшууллын хорооны журамд заагдсан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс компанид хохирол учирсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

Гишүүдийн нэр:

Хорооны дарга Д.Алтанхуяг

Боловсрол: МУИС сургуулийг 1993 онд Электроник инженер мэргэжлээр, Зах зээлийн судалгааны хүрээлэн 1995 онд Гадаад худалдааны менежер, Удирдлагын академийг 2005 онд Удирдахуйн ухааны магистраар суралцаж төгссөн.

Ажил эрхлэлт: 2005 оноос "Дорнод интернэшнл" компанид Гүйцэтгэх захирал, 2012 оны 01-р сараас өнөөг хүртэл "Аэр Зам" ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Хорооны гишүүн Ц.Эрдэнэбаяр

Боловсрол: 2001-2004 онд Улаанбаатар-Эрдэм судлал их сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн.

Ажил эрхлэлт: 2000-2002 онд "Монос фарм" ХХК-д Экспидитор, 2004-2005 онд "Чоён Файнан"с ХЗХ-д Зээлийн эдийн засагчаар, 2006 оноос "Хера Фүүдс" ХХК-ийн Дэд захирлаар, 2007 оноос "Хера Холдинг"-ийн Тэргүүн дэд Ерөнхийлөгчөөр ажиллаж байна. Ремикон компанийн ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны даргаар ажиллаж байна.

Хорооны гишүүн С.Баянмөнх

Боловсрол: АНУ-ын "TEXAS WESLEYAN UNIVERSITY" сургуулийг Бизнесийн Удирдлагын Магистр, МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ КТМС-ийг Бизнесийн Удирдлагын Магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Ажил эрхлэлт: АНУ-ын "RED HORSE REALTY" INC Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн шинжээч, "ORIENTAL GARDEN" INC Борлуулалтын туслах менежер, МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ, КТМС-д Багш, 2012 оноос одоог хүртэл "BP MONGOLIA GROUP" ХХК-д Гүйцэтгэх захирлын албан тушаал эрхэлж байна.

1. Төлбөрийн чадварын шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2023 он	2024 он
Төлбөрийн чадварын шинжилгээ	Цэвэр эргэлтийн хөрөнгө	14,096,565,700	20,939,702,366
	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	1.8	2.2
	Түргэн хөрвөх хөрөнгө	19,428,346,085	26,497,082,645
	Эргэлтийн харьцаа	2.3	2.74
	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0.78	0.84
	Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0.56	0.53
	Төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин	0.33	0.22

Төлбөрийн чадварын шинжилгээнээс харахад Ремикон ХК нь 2023 оноос 2024 онд илүү сайжирсан үзүүлэлттэй байна.

Цэвэр эргэлтийн хөрөнгө өнгөрсөн онтой харьцуулахад 6.8 тэрбум төгрөг, Түргэн хөрвөх хөрөнгө 7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа, Эргэлтийн харьцаа өнгөрсөн онтой харьцуулахад өссөн байгаа нь компанийн санхүүгийн байдал сайжирч, богино хугацааны өр төлбөрөө төлөхөд илүү боломжтой болжээ.

Төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин 2023 онд 33% байсан бол 2024 онд 22% болж буурсан нь компанийн төлбөрийн асуудал буурч байгааг харж болно.

2. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2023 он	2024 он
Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ	Бие даах чадварын коэффициент	0.50	0.53
	Санхүүгийн хамаарлын коэффициент	2.05	0.89
	Зохицуулалтын коэффициент	0.90	1.78
	Өөрийн эргэлтийн хөрөнгө	14,096,565,700	20,939,702,366
	Өр төлбөрийн хувийн жин	0.50	0.47
	Урт хугацаат зээл болон эздийн өмчийн харьцаа	0.43	0.31
	Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа	1.02	0.89

Бие даах чадварын коэффициент нь компанийн санхүүгийн эрсдлийг үнэлэх, өр төлбөрийн менежмент болон бие даасан санхүүжилтийн түвшинг илтгэдэг. Ремикон ХК-ий хувьд 2024 онд 0.53 гэсэн үзүүлэлттэй байгаа нь компанийн санхүүжилтийн 53% нь өөрийн хөрөнгөөс бүрдэж байна.

Санхүү хамаарлын коэффициент 2023 онд 2.05 байснаас 2024 онд 0.89 болж буурсан нь компанийн өрийн хэмжээ багасаж, эздийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэж санхүүгийн тогтвортой байдал сайжирсан байна.

Өр төлбөрийн хувийн жин, харьцааны үзүүлэлтүүд өнгөрсөн онтой харьцуулахад буурсан байгааг харвал эздийн хөрөнгө нэмэгдэж санхүүгийн байдал сайжирсаар байгааг харж болно.

3. Төлбөрийн хэтийн боломжийн үзүүлэлтүүд

Санхүүгийн харьцаа		2023 он	2024 он
Төлбөрийн хэтийн боломжийн үзүүлэлтүүд	Хүү төлөх чадвар	8.10	9.00
	Хүү ба үндсэн өрийг төлөх чадвар	2.10	2.33

Хүү төлөх чадварын коэффициент нь нэг төгрөгийн хүүг төлөх татварын өмнөх ашгийн хэмжээг харуулдаг. Энэ үзүүлэлт нэгтэй тэнцүү байхад болно гэж үздэг бол компанийн хувьд 9 төгрөг байгаа нь зээлийн хүү төлөх чадвартайг нотолж байна.

4. Эргэцийн шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2023 он	2024 он
Эргэцийн шинжилгээ	Авлагын эргэц /удаа/	1.64	1.56
	Авлагын эргэц /өдөр/	219	233.00
	Бараа материалын эргэц /удаа/	8	29.69
	Бараа материалын эргэц /өдөр/	46	12.3
	Эргэлтийн хөрөнгийн эргэц /удаа/	1.23	1.25
	Эргэлтийн хөрөнгийн эргэц /өдөр/	293	293
	Нийт хөрөнгийн эргэц	0.96	0.92
	Өглөгийн эргэц /удаа/	0.39	1.56
	Өглөгийн эргэц /өдөр/	926.43	233.42
	Үйлдвэрлэлийн циклийн хугацаа	265	273.14
	Санхүүгийн циклийн хугацаа	(661)	132

Эргэцийн шинжилгээг авч үзвэл бараа материал 12.3 өдөрт, эргэлтийн хөрөнгө 293 өдөрт, авлага болон өглөг 233 өдөрт эргэлдэж байгаа бол үйлдвэрлэлийн цикл 273 өдөр байна. Эдгээр үзүүлэлтүүд нь авлагын эргэц удаан, үйлдвэрлэлийн процесс удаашралтай байгааг харуулж байна.

5. Бүтээмжийн шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2023 он	2024 он
Бүтээмжийн шинжилгээ	Хөдөлмөрийн бүтээмж	530,092,980	624,681,941
	Үндсэн хөрөнгийн ачаалал	6.14	8.31
	Материал өгөөмж	10.83	4.02
	Үндсэн хөрөнгийн хувийн жин	0.16	0.11
	ҮХ-ийн нийт дүнд үйлдвэрлэлийн зориулалттай ҮХ-ийн хувийн жин	0.8	0.8
	ҮХ-ийн элэгдлийн коэффициент	7%	17.58%

Бүтээмжийн шинжилгээнээс харахад 2024 онд компанийн нэг ажилчин 624.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн бүтээж ажиллажээ. Мөн 1 төгрөгийн үндсэн хөрөнгө 8.31 төгрөгийн орлого бүтээж байна.

6. Ашигт ажиллагааны шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2023 он	2024 он
Ашигт ажиллагааны шинжилгээ	Борлуулалтын ашигт ажиллагаа	0.28	0.33
	Өртгөөр тооцсон борлуулалтын ашигт ажиллагаа	0.39	0.33
	Хөрөнгийн ашигт ажиллагаа	0.13	0.14
	Эздийн өмчийн ашигт ажиллагаа	0.26	0.26

Ашигт ажиллагааны шинжилгээнээс харахад нэг төгрөгийн борлуулалтаас 0.33 төгрөгийн ашиг олж байна. Өөрөөр хэлбэл нэгж бүтээгдэхүүнээс 33%-ийн ашиг олж байна гэсэн үг.

Хөрөнгийн ашигт ажиллагааг харвал нэг төгрөгийн хөрөнгөөр 0.14 төгрөгийн ашгийг бүтээж байгаа бол нэг төгрөгийн эздийн өмчөөр 0.26 төгрөгийн ашиг олж байна.

7. Зах зээлийн идэвхжлийн шинжилгээ

Санхүүгийн харьцаа		2023 он	2024 он
Зах зээлийн идэвхжлийн шинжилгээ	Зах зээлийн үнэ ба ашгийн харьцаа	0.46	0.97
	Зах зээлийн үнэ ба бүртгэлийн үнийн харьцаа	0.24	0.66
	Нэгж хувьцааны бүртгэлийн үнэ	100.00	100.00

Зах зээлийн үнэ ашгийн харьцаа нь хувьцааны үнэ цэнийн өсөлтийг харуулдаг үзүүлэлт юм. Манай компанийн хувьд хувьцааны анхны үнэ 100 төгрөг байсан бол одоо 66 төгрөг болж унасан боловч өнгөрсөн онтой харьцуулахад 2.75 дахин өссөн үзүүлэлттэй байна.



“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнес оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110008

Цахил: шуудан: www.shonkhor.mn

И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2025.02.07 № 25/23

Тайлбар _____ -ны № _____ -т

“Санхүүгийн зохицуулах
хороо”-нд

Тодорхойлолт хүргэх нь

Шонхор үнэлгээ Аудит ХХК болон Ремикон ХК
хооронд 2024 оны 2 дугаар сарын 3-ны өдөр
байгуулагдсан 25/23 тоот гэрээний дагуу тус компанийн
2024 оны санхүүгийн тайлангийн Аудит хийгдэж байгаа
нь үнэн болно.

Хүндэтгэсэн
Захирал



Шийрэг

Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01 нээс 2024 оны 12 дугаар сарын 31	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Ремикон ХК 9010001071 RMC 7777-7704	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Гаули ҮЦК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Барилгын материал үйлдвэрлэл	
Жилийн эцсийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-д бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Шонжор үнэлгээ аудит ХХК,	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо	78679464	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Ремикон ХК Ерөнхий нягтлан бодогч Э.Эрдэнэцэцэг	
1	Жилийн санхүүгийн тайлан	
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Нийт хөрөнгийн дүн 39,323,889,795.36 Нийт өр төлбөр ба эздийн өмч 39,323,889,795.36	
Орлогын тайлан	Борлуулалтын орлого 36,231,552,591.57 Татвар төлөхийн өмнөх ашиг 5,999,203,903.80	
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Өмч ашиг алдагдалын дүнгээр өсөөд өмчийн дүн 20,801,480,819.10	
Мөнгөн гүйлгээний тайлан	Бүх цэвэр мөнгөн орлогын дүн 21,802,737,606.2	
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
Аудитын ажил хийгдэж байгаа		
1.2	Аудитын тодорхойлох захидал	
Цаасаар хавсаргав		
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгссөн үнэлгээ, цаашид авч	
2.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөхцөл, боломжийн үзүүлэлт	
	Цаасаар хавсаргав	Цаасаар хавсаргав
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Цаасаар хавсаргав
2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл	Худалдаа хөнгөлийн баннаас эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх зорилгоор 3,000,000,000 төгрөгийн зээлийг 2024.06 сард авсан. 2025 оны 08-12 сард эргэн төлөлтийн хуваарьтай
3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын Сонирхлын зөрчилтэй хэлцэл, ажил гүйлгээ байхгүй	
4	Цалин урамшууллын мэдээлэл	
	2024 онд цалин урамшуулалд 2,179,199,811.66 төгрөг олгосон байна. Үүнээс ТУЗ болон хараат бус гишүүдэд 9800,000 цалин хөлс олгосон	
5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	Цаасаар хавсаргав	
6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл	
	1. Барилгын салбар дахь орон сууцны үнийн хөөрөгдөлөөс нөлөөтэй салбар үнэлтээс үүдэн авлага төлөгдөхгүй болон мөнгө эргэлдэхгүй байгаа нь буцаад түүхий эд материал татах, эргэлтийн хөрөнгөгүйдэх эрсдэл үүсгэж байна.	
7	Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл	
	Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо
	1. Хассуурь Ганхуяг	35,352,294.00
	2. Imperia Mongolia Holding LTD	16,336,692.00
	3. Хера холдинг ХХК	5,310,344.00
	4. Lee Jung Suk	3,401,352.00
	5. БИДИСЕК ҮЦК ХК	2,728,013.00
8	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгосон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлсэнээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	
	Төслийн зорилгоор нийтэд зориулж хувьцаа гаргаагүй	
9	Ногдол ашгийн мэдээлэл	
	2024 оны санхүүгийн тайлангаар ашигтай гарсан хэдий ч ногдол ашиг гарах нь компанийн үйл ажиллагаанд эрсдэл үүсүүлж байгаа тул компанийн дүрмийн 6-р зүйлийг үндэслэн ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн.	
10	Үнэт цаас гаргачаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажил тайлангийн мэдээлэл	
	1. Ажилчдаа болон тэдгээрийн ар гэрт нэг удаагийн тэтгэмж байдлаар мөнгөн дүнгээр 18,520,200 төгрөгийн үйл ажиллагааны бус зардал гаргасан байна.	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийг үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Э.Мөнхсайхан	Овог, нэр: Д.Шийрэг	
Албан тушаал: "Ремикон" ХК-ийн Гүйцэтгэх захирал	Албан тушаал: "Шонжор Үнэлгээ Аудит" ХХК-ийн Захирал	
Гарын үсэг:	Гарын үсэг:	
(Тамга/тэмдэг)	(Тамга/тэмдэг)	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Э.Эрдэнэцэцэг		
Албан тушаал: "Ремикон" ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч		
Гарын үсэг:		